





## ГАРЧИГ

- Ерөнхий тэмдэглэл .....
- Аргачлалын тайлбар.....
- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд .....
- IV. Гэмт хэрэг .....
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй .....
- VIII. Аж үйлдвэр .....
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй\* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### • Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

### • Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны эхний 2 сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.



- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

- ✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

- ✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



## Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2017 оны 2 дугаар сарын байдлаар)



### I. Нийгмийн байдал

#### I.1 Ажил хайгч иргэд


2017 оны 2 сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 436, ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 286 байгаагийн 157 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 141 буюу 2.0 дахин өсч, өмнөх сараас 41 буюу 12.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хоёрдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 42 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 8 буюу 23.5 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант сард 19 иргэн ажилд зуучлуулсны 10 буюу 52.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучилсан иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 35.7 хувиар өслөө.

Зураг. I.1

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 53, 25-34 насны 109, 35-44 насны 69, 45-54 насны 44, 55-59 насны 11 иргэн байна.

#### I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 2 сарын байдлаар 54 эх амаржиж, 55 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 12 буюу 18.2 хувиар, төрсөн хүүхдийн тоо 12 буюу 17.9 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 17, бүртгүүлсэн гэр бүл 11, цуцалсан гэр бүл 6 байгаа нь өмнөх оны мөн үеэс нас баралт 2 буюу 10.5 хувиар буурч, цуцалсан гэр бүл 3 буюу 2 дахин, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 37.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайланд хугацаанд 1 хүүхэд үрчлэгдсэн.

Зураг. I.2



Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



## II. Нийгмийн даатгал, халамж

### II.1 Нийгмийн даатгал

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 2 сарын байдлаар 1544.2 сая төгрөг, зарлага 1612.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 789.9 сая төгрөгөөр буюу 1.9 дахин, зарлага 225.7 сая төгрөгөөр буюу 16.3 хувиар тус тус өслөө.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.9 дахин өсөхөд ЭМД сангийн орлого 2.1 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт 136.2 хувьтай байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 оны эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсөхөд тэтгэмж болон ЭМД-ын сангаас зарлага 1.4-1.5 дахин өссөн нь голлон нөлөөлөв. Зарлагын төлөвлөгөөний биелэлт 90.3 хувьтай байна.

### II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 2 сарын байдлаар 2928 хүнд 344.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 905 хүн буюу 44.7 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 149.3 сая төгрөг буюу 76.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны эхний 2 сарын байдлаар 703 хүн хамруулж 121.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 220 хүн буюу 23.8 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 11.8 сая төгрөг буюу 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны эхний 2 сарын байдлаар 2216 хүн хамруулж 223.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1116 хүн буюу 2.0 дахин, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 161.1 сая төгрөг буюу 3.6 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### II.3 Дундаж цалин


Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 2 сарын мэдээгээр 172 байгууллагын 4300 даатгуулагч иргэн, үүнээс 420 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл



төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 320 ажилтны дундаж цалин 811.5 мянган төгрөг, төсөвт 53 байгууллагын 1467 ажилтны дундаж цалин 713.8 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 611 ажилтны дундаж цалин 1252.9 мянган төгрөг, 92 ХХКомпаний 1366 ажилтны дундаж цалин 1065.2 мянган төгрөг, бусад 14 аж ахуйн нэгж байгууллагын 116 ажилтны дундаж цалин 440.1 мянган төгрөг боллоо.

Зураг II.1

Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны эхний 2 сарын байдлаар




### III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 2 сарын байдлаар 63 эх амаржиж 2016 оны мөн үетэй харьцуулахад 4 буюу 6.8 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 63 үүнээс 33 нь хүү, 30 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 5 буюу 8.6 хувиар өссөн байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний эхний 2 сарын байдлаар

Зураг III.1



0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна.





Халдварт өвчин эхний 2 сарын байдлаар 28 буюу 10000 хүн амд 17.1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор нэмэгджээ.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 17799 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 2945 буюу 14.2 хувиар буурч, 882 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 119 буюу 15.6 хувиар өссөн байна.

2017 оны эхний 2 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 1270, халдварт өвчин 28 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл,  
жил бүрийн эхний 2 сарын байдлаар






#### IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 2 сарын байдлаар 40 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11 буюу 37.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо өсөхөд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 6 буюу 46.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 4, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 78 болсон нь илрээгүй гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар буурч, илрүүлэлтийн хувь 6.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 28 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 10 буюу 55.6 хувиар өссөн байна.


Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний 2 сарын байдлаар 53 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 20.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 12 сая төгрөгөөр буюу 29.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4.0 сая төгрөг буюу 25.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны эхний 2 сарын байдлаар 109 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 хүнээр буюу 18.0 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо  
жил бүрийн эхний 2 сарын байдлаар**V. Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 5.8 пунктээр, 2016 оны жилийн эцсээс 2.3 пунктээр, өмнөх сараас 1.5 пунктээр тус тус өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс, 2017 оны эхний 2 сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2017.II}{2016.II}$	$\frac{2017.II}{2016.XII}$	$\frac{2017.II}{2016.I}$
Ерөнхий индекс	105.8	100.6	101.5
Хүнсний бараа, ундаа, ус	106.9	104.6	104.4
Согтууруулах ундаа, тамхи	101.3	100.5	98.6
Хувцас, бөс бараа, гутал	108.7	102.9	100.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	106.9	100.2	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.0	99.7	99.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.9	100.9	100.0
Тээвэр	101.3	101.8	101.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	97.8	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	124.5	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.4	100.9	100.9

**VI. Орон нутгийн төсөв**


2017 оны эхний 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2670.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 2543.5 сая төгрөг болж 95.2 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 3251.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 2320.2 сая төгрөг болж 71.4 хувийн биелэлттэй байна.

2017 оны эхний 2 сарын байдлаар авлагын үлдэгдэл 29.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 43.1 сая төгрөг байна.

Зураг VI.1


Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 660 буюу 0.4 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 88.2 хувьтай байна. 2017 оны эхний 2 сарын байдлаар 279 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 11.4 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 10.0 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VIII.1


Төл бойжилт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, толгойгоор





Зураг VIII.2

Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, толгойгоор




### VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны эхний 2 сарын байдлаар 9615.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 555.1 сая төгрөг буюу 6.1 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 384.4 сая төг буюу 4.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 9946.4 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 861.7 сая төгрөг буюу 9.5 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 92.8 хувь буюу 8.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.2 хувь буюу 9.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр





## IX. Цаг агаарын мэдээ 2 сарын байдлаар


Хур тунадас: Нийт 1.7 мм хур тунадас орсон.

Салхи: Ихэнх хугацаанд секундэд 4 -12 метр, хамгийн их хурд нь 12 м/сек байсан.


Агаарын температур: Дунджаар -11.9 градус хүйтэн байлаа.

### 2017 оны 3 дугаар сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж 5-10 градус хүйтэн байдаг бөгөөд уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй. Говьсүмбэр аймгийн нутгаар уур амьсгалын дунджаар 04.-2.5 мм хүртэл хур тунадас ордог бөгөөд энэ сард дунджаас ахиу хур тунадас орох төлөвтэй.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж(°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	58	63	108.6
Ажил хайгч ажилгүй иргэд, 2 дугаар сард	хүн	145	286	197.2
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	31	28	90.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	29	40	137.9
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	2366.6	2543.5	107.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	1973.0	2320.2	117.6
Авлага	сая.төг	20.8	29.0	139.4
Өглөг	сая.төг	441.6	43.1	9.8
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	9060.4	9615.5	106.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	9084.7	9946.4	109.5
Төллөсөн хээлтэгч	толгой	569	660	116.0
Гарсан төл	толгой	569	662	116.3
Хорогдсон төл	толгой	85	78	91.8
Бойжсон төл	толгой	484	584	120.7
Том малын зүй бусын хорогдол	толгой	2453	279	1137.4



## I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Ажил хайгч ажилгүй иргэд	145	286	197.2
Үүнээс эмэгтэй	83	157	189.2
Ажлын байрны захиалга	34	42	123.5
Ажилд зуучлагдсан иргэд	14	19	135.7
Үүнээс эмэгтэй	8	10	125.0

## I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Амаржсан эх	66	54	81.8
Төрсөн хүүхэд	67	55	82.1
Үрчлэгдсэн хүүхэд	0	1	*
Бүртгүүлсэн гэр бүл	8	11	137.5
Цуцалсан гэр бүл	3	6	200.0
Нас баралт	19	17	89.5

## II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сангийн төрөл	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	674.3	1544.2	229.0
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	618.5	1612.3	260.7





## II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II		2017 II		$\frac{2017 \text{ II}}{2016 \text{ II}}\%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	2023	195.5	2928	344.8	144.7	176.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	923	133.2	703	121.4	76.2	91.1
Халамжийн тэтгэвэр	240	65.8	217	64.8	90.4	98.8
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	683	67.3	495	56.6	72.5	84.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	1100	62.3	2216	223.4	201.5	358.6
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	479	30.7	605	57.0	126.3	185.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	86	9.2	38	2.3	44.4	25.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	363	5.7	379	6.8	104.4	119.3
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	164	14.4	234	24.8	142.7	172.2
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	7	2.3	5	1.7	71.4	73.9
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1	0.1	955	130.8	95500.0	130800.0



## III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 \text{ II}}{2016 \text{ II}}\%$
Төрсөн эх	59	63	106.8
Амьд төрсөн хүүхэд	58	63	108.6
Эрэгтэй	32	33	103.1
Эмэгтэй	26	30	115.4
Амьгүй төрөлт	1	0	*
Нийт нас баралт	13	16	123.1
Эмнэлгийн нас баралт	2	2	100.0
Хоног болоогүй нас баралт	0	2	*
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0	*
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	1	50.0
Эмчлэгдсэн өвчтөн	763	882	115.6
Амбулаторийн үзлэг	20744	17799	85.5
Халдварт өвчин	31	28	90.3



## IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 2 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>29</b>	<b>40</b>	<b>137.9</b>
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	13	19	146.2
Өмчлөх эрхийн эсрэг	12	16	133.3
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	1	1	100.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	3	*
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	0	*
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	1	50.0
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0	0	*
Бусад гэмт хэрэг	0	0	*
<b>Гэмт хэрэгт <u>холбогдог</u>сод</b>	<b>26</b>	<b>51</b>	<b>196.2</b>
15 хүртэлх насны	1	0	*
16-34 насны	18	31	172.2
35-с дээш	7	20	285.7
Боловсрол – Дээд	5	10	200.0
Боловсрол - Тусгай дунд	1	3	300.0
Боловсрол – Бүрэн дунд	12	14	116.7
Боловсрол – Бүрэн бус дунд	3	15	500.0
Боловсрол – Бага	4	3	75.0
Боловсролгүй	1	6	600.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	6	300.0
Ажилгүй иргэд үйлдсэн	16	22	137.5
Эмэгтэй хүн оролцсон	4	4	100.0
Хүүхэд оролцсон	2	4	200.0
Бүлгээр үйлдсэн	3	4	133.3
Согтуугаар үйлдсэн	11	14	127.3
<b>Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал</b>	<b>29</b>	<b>40</b>	<b>137.9</b>
Гудамж талбайд	9	9	100.0
<u>ГХ-н</u> улмаас нас барсан	0	0	*
<u>ГХ-н</u> улмаас гэмтсэн	18	28	155.6
Учирсан хохирол / сая.төг /	41	53	129.3
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	16.0	20.0	125.0



## VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Нийт орлого	2366.6	2543.5	107.5
Урсгал орлого	925.1	857.4	63.5
Татварын орлого	871.6	736.8	84.5
Татварын бус орлого	53.5	120.7	225.6
Тусламжийн орлого	1441.5	1686.1	117.0

## VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2016 X}{2016 II} \%$
Нийт зарлага	1973.0	2320.2	117.6
Урсгал зардал	1917.0	2276.9	118.8
Хөрөнгийн зардал	56.0	43.3	77.3

## VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Авлага	20.8	29.0	139.4
Өглөг	441.6	43.1	9.8
Төсөвт байгууллагын тоо	51	49	96.1
Төсөвт байгууллагын ажиллагсад	769	783	101.8



## VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Бүгд	569	660	116.0
Ингэ	0	0	*
Гүү	7	0	*
Үнээ	161	88	54.7
Эм хонь	177	428	241.8
Эм ямаа	224	144	64.3

## VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Дүн	569	660	116.0
<u>Баянтал</u>	298	53	17.8
Сүмбэр	215	607	282.3
<u>Шивээговь</u>	56	0	*

## VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Бүгд	484	584	120.7
Ботго	0	0	*
Унага	6	0	*
Тугал	149	83	55.7
Хурга	139	376	270.5
Ишиг	190	125	65.8

## VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Дүн	484	584	120.7
<u>Баянтал</u>	276	51	18.5
Сүмбэр	177	533	301.1
<u>Шивээговь</u>	31	0	*



## VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Бүгд	2453	279	11.4
Тэмээ	0	0	*
Адуу	53	2	3.8
Үхэр	118	14	11.9
Хонь	901	68	7.5
Ямаа	1381	195	14.1

## VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Дүн	2453	279	11.4
<u>Баянтал</u>	634	132	20.8
Сүмбэр	1483	147	9.9
<u>Шивээговь</u>	336	0	*

## VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Бүгд	284	28	9.9
Тэмээ	0	0	*
Адуу	13	0	*
Үхэр	32	0	*
Хонь	76	10	13.2
Ямаа	163	18	11.0

## VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Дүн	284	28	9.9
<u>Баянтал</u>	73	5	6.8
Сүмбэр	77	23	29.9
<u>Шивээговь</u>	134	0	0



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийт	9060.4	9615.5	106.1
Нүүрс	8537.3	8921.7	104.5
Дулаан	477.5	506.9	106.2
Цэвэр ус	33.3	51.3	154.1
Сувагжуулалт	12.3	18.4	149.6
Бусад	0.0	117.6	*

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийт	9084.7	9946.4	109.5
Нүүрс	8561.6	9366.4	109.4
Дулаан	521.5	552.5	105.9
Усан хангамж, ус ариутгал	1.6	1.2	75.0
Бусад	0.0	26.3	*

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 II	2017 II	$\frac{2017 II}{2016 II} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	8561.6	9366.4	109.4
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	8537.3	8921.7	104.5
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	380.8	394.8	103.7
Ажиллагсад	595	567	95.3



Е-майл хаяг:

Вэб хаяг:

Мэдээллийн сангийн хаяг:

Утас:

[govisumber@nso.mn](mailto:govisumber@nso.mn)

[govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)

70543222, 70543017